


**МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ
ТЭНЦЭЛ, ГОЛ НЭР ТӨРЛИЙН ЭКСПОРТ,
ИМПОРТЫН ТОО ХЭМЖЭЭ, ҮНЭ БОЛОН
ТАТВАРЫН ОРЛОГО БҮРДЭЛТИЙН ТАЛААРХ
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Их Хурлын <http://parliament.mn/c/pwyo> цахим хаягаар, эсхүл дараах QR кодыг ашиглан бусад танилцуулга, мэдээтэй танилцана уу.



МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ, ГОЛ НЭР ТӨРЛИЙН ЭКСПОРТ, ИМПОРТЫН ТОО ХЭМЖЭЭ, ҮНЭ БОЛОН ТАТВАРЫН ОРЛОГО БҮРДЭЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА



Нэг. Гадаад худалдааны үзүүлэлт

Гадаад худалдааны нийт бараа эргэлт: 2,976.3 сая ам.доллар буюу 13.4 хувиар өсчээ. 2024 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлт **25,163.5** сая ам.доллар болж 2023 оны мөн үеэс Экспортын дүн импортын дүнгээс 4,029.3 сая ам.доллараар давж, гадаад худалдааны баланс эерэг гарлаа.

Хүснэгт 1. Гадаад худалдааны үзүүлэлт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	эхний 11 сар				Өөрчлөлт	
	2021	2022	2023	2024	Дүн	Хувь
Нийт эргэлтийн бараа	14,983.0	19,021.0	22,187.2	25,163.5	2,976.3	13.4
-Экспорт	8,794.9	11,148.4	13,811.4	14,596.4	785.0	5.7
-Импорт	6,188.2	7,872.5	8,375.8	10,567.1	2,191.3	26.2
Тэнцэл	2,606.7	3,275.9	5,435.7	4,029.3	-1,406.3	-25.9

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Гадаад худалдааны тэнцэл: 2024 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны тэнцэл **4,029.3** сая ам.долларын ашигтай гарсан байна. Өмнөх оны мөн үеэс 1,406.3 сая ам.доллараар буурахад импорт 2,191.3 сая ам.доллараар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Импорт: 2024 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр импорт **10,567.1** сая ам.долларт хүрч, 2023 оны мөн үетэй харьцуулахад 2,191.3 сая ам.доллар буюу 26.2 хувиар өссөн байна.

Экспорт: 2024 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр **14,596.4** сая ам.доллар болж, 2023 оны мөн үетэй харьцуулахад 785.0 сая ам.доллар буюу 5.7 хувиар өссөн байна.

Хоёр. Гол нэр төрлийн экспортын бүтээгдэхүүн

Нийт экспортын **87.2** хувийг эрдсийн бүтээгдэхүүний экспорт, **12.8** хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт эзэлж байна.

сая ам.доллар буюу 6.6 хувиар өссөн бол эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт **1,870.4** сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.7 сая ам.доллар буюу 0.1 хувиар өссөн байна.

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт **12,726.0** сая ам.доллар болж, өмнөх оноос 783.3

Хүснэгт 2. Эрдсийн болон эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	эхний 11 сар				Өөрчлөлт		Нийт экспортод эзлэх хувь
	2021	2022	2023	2024	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний экспорт	6,309.0	8,518.3	11,942.8	12,726.0	783.3	6.6	87.2
Эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт	1,214.6	1,515.6	1,868.7	1,870.4	1.7	0.1	12.8
Нийт экспорт	7,523.5	10,033.9	13,811.4	14,596.4	785.0	5.7	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ЭКСПОРТЫН ЗАРИМ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ТОО ХЭМЖЭЭ БОЛОН ҮНИЙН ДҮН

Нийт экспортын 55.2 хувийг нүүрс, 20.1 хувийг зэсийн баяжмал, 5.8 хувийг алт, 2.0 хувийг газрын тос, 1.9 хувийг жонш, 1.1

хувийг цайрын баяжмал тус тус эзэлсэн байна.

Хүснэгт 3. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээ, төрлөөр

Барааны төрөл	Хэмжих нэгж	эхний 11 сар		Өмнөх оны мөн үеэс	
		2023	2024	Дүн	Хувь
Зэсийн баяжмал	мян.тн	1,392.6	1,514.2	121.6	8.7
Нүүрс	сая.тн	59.7	74.0	14.3	24.0
Төмрийн хүдэр	сая.тн	5.1	6.8	1.7	32.7
Цайрын баяжмал	мян.тн	144.1	115.3	-28.8	-20.0
Алт	тн	10.6	11.0	0.4	3.7
Түүхий нефть болон газрын тос	сая.баррель	4.3	3.7	-0.6	-13.8
Тунгаасан зэс ба хайлш	мян.тн	11.9	11.5	-0.5	-4.1
Жоншны баяжмал	мян.тн	978.6	1,197.5	218.9	22.4
Адууны мах	мян.тн	30.3	21.4	-8.8	-29.2
Өлөн гэдэс	тн	562.2	742.2	180.0	32.0

Үхэр, адууны боловсруулсан шир	сая.дм2	10.0	42.5	32.5	324.4
Үхэр, адууны боловсруулаагүй шир	мян.ш	445.2	280.9	-164.3	-36.9
Хонь, хурганы боловсруулсан арьс	сая.дм2	38.8	0.4	-38.4	-99.0
Ямаа, ишигний боловсруулсан арьс	сая.дм2	54.7	44.7	-10.0	-18.2
Ямааны самнасан ноолуур	тн	863.1	625.5	-237.5	-27.5
Ямааны угаасан ноолуур	мян.тн	5.4	4.8	-0.6	-11.3
Хонины самнаагүй ноос	мян.тн	12.6	7.6	-4.9	-39.2

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Хүснэгт 4. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын орлого

/сая ам.доллар/

Барааны төрөл	эхний 11 сар		Өмнөх оны мөн үеэс		Экспортод эзлэх хувь
	2023	2024	Дүн	Хувь	
Зэсийн баяжмал	2,409.2	2,937.2	528.0	21.9	20.1
Нүүрс	7,931.5	8,053.4	122.0	1.5	55.2
Төмрийн хүдэр	238.5	57.5	-181.0	-75.9	0.4
Цайрын баяжмал	211.4	167.3	-44.2	-20.9	1.1
Алт	665.1	846.1	181.0	27.2	5.8
Түүхий нефть болон газрын тос	335.5	297.6	-38.0	-11.3	2.0
Тунгаасан зэс ба хайлш	97.9	101.7	3.9	3.9	0.7
Жоншны баяжмал	246.7	282.0	35.3	14.3	1.9
Адууны мах	116.0	75.7	-40.3	-34.8	0.5
Өлөн гэдэс	8.6	13.1	4.4	51.4	0.1
Үхэр, адууны боловсруулсан шир	0.6	1.0	0.4	57.9	0.0
Үхэр, адууны боловсруулаагүй шир	0.9	0.7	-0.2	-25.9	0.0
Хонь, хурганы боловсруулсан арьс	0.6	0.0	-0.6	-99.3	0.0
Ямаа, ишигний боловсруулсан арьс	1.3	1.1	-0.2	-16.4	0.0
Ямааны самнасан ноолуур	83.4	60.1	-23.3	-28.0	0.4
Ямааны угаасан ноолуур	261.1	256.7	-4.4	-1.7	1.8
Хонины самнаагүй ноос	13.1	8.3	-4.9	-37.0	0.1
Нийт экспортод эзлэх хувь	90.4	91.8	0.0		90.2

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт өнгөрсөн оны мөн үеэс 783.3 сая ам.доллар буюу 6.6 хувиар өсөхөд голлон нөлөөлсөн бүтээгдэхүүнүүдийг авч үзвэл:

Нүүрс: 2024 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр 74.0 сая тонн нүүрс экспортолж, 8,053.4 сая ам.долларын экспортын орлого олжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нүүрсний экспортын биет хэмжээ 14.3 сая тонноор өссөн бол экспортын орлого мөн 122.0 сая ам.доллараар буюу 1.5 хувиар өссөн байна. Нэг тонн нүүрсний экспортын дундаж үнэ 108.8 ам.доллар болж өмнөх оны мөн үеэс 24.1 ам.доллар буюу 18.1 хувиар буурсан боловч нүүрсний экспортын биет хэмжээний өсөлт экспортын орлого өсөхөд нөлөөлсөн байна. Нүүрсийг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

Зэсийн баяжмал: 2024 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр зэсийн баяжмалын экспортын орлого өнгөрсөн оны мөн үеэс 21.9 хувь буюу 528.0 сая ам.доллараар өсч, 2,937.2 сая ам.долларт хүрсэн байна. Зэсийн баяжмалын экспортын биет тоо хэмжээ 1,514.2 мянган тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 8.7 хувь буюу 121.6 мянган тонноор өсөхөд экспортын дундаж үнэ 1,730.1 ам.доллараас 1,939.8 ам.долларт хүрч 209.8 ам.доллараар өссөн нь экспортын орлого өсөхөд гол нөлөө үзүүлжээ.

Зэсийн баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

Алт: 2024 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр алтны экспортын тоо хэмжээ 11.0 тоннд хүрч, 846.1 сая ам.долларын экспортын орлого олсон байна. Алтны экспортын биет хэмжээ өмнөх оны мөн үеэс 3.7 хувиар өссөн байна. Алтны экспортын орлого 846.1 сая ам.долларт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 27.2 хувь буюу 181.0 сая ам.доллараар өсчээ. Харин нэг тонн алтны экспортын дундаж үнэ 22.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Алтны 81.3 хувийг Швейцар, 18.4 хувийг АНУ руу тус тус экспортолсон байна.

Нефть: 2024 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр газрын тосны экспортын тоо хэмжээ 3.7 сая баррельд хүрч, 297.6 сая ам.долларын экспортын орлого олсон байна. Газрын тосны экспортын орлого өмнөх оны мөн үеэс 11.3 хувь буюу 38.0 сая ам.доллараар буурахад газрын тосны биет хэмжээ 13.8 хувь буюу 0.6 сая баррелиар буурсан байна. Газрын тосыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

Гурав. Гол нэр төрлийн импортын бүтээгдэхүүн

Манай улс дэлхийн 155 орноос гарал үүсэлтэй бараа импортлосноос БНХАУ-д 40.2 хувь; ОХУ-д 24.0 хувь; Япон-д 10.4 хувь; АНУ-д 4.5 хувь; БНСУ-д 4.2 хувь тус тус ногдож байгаа нь нийт импортын дүнгийн 83.4 хувийг эзэлж байна.

Нийт импортын **20.8** хувийг эрдсийн бүтээгдэхүүний импорт, **79.2** хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт тус тус эзэлж

байна.

Эрдсийн бүтээгдэхүүний импорт **2,199.5** сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 285.4 сая ам.доллараар буюу 14.9 хувиар өссөн байна. Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт **8,367.6** сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 1,905.9 сая ам.доллар буюу 29.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 6. Эрдсийн болон эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	эхний 11 сар				Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
	2021	2022	2023	2024	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний импорт	991.8	1,580.6	1,914.0	2,199.5	285.4	14.9	20.8
Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт	4,653.3	5,520.5	6,461.7	8,367.6	1,905.9	29.5	79.2
Нийт импорт	5,645.2	7,101.1	8,375.8	10,567.1	2,191.3	26.2	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Импортын барааны бүтцийн хувьд эрдэс бүтээгдэхүүн 22.9 хувь, машин механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг 15.9 хувь, авто болон агаарын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги 13.1 хувь, мал амьтан, ургамлын

гаралтай бүтээгдэхүүн, хүнсний зүйл 9.9 хувь, үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн 9.4 хувь, химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн 7.4 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 7. Импортын гүйцэтгэл, барааны бүлгээр

/сая ам.доллар/

№	Барааны нэр	эхний 11 сар		Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
		2023	2024	Дүн	Хувь	
1	Амьд мал, амьтад, мал амьтдын гаралтай бүтээгдэхүүн	25.6	41.1	15.5	60.7	2.4
2	Ургамлын гаралтай бүтээгдэхүүн	83.6	38.4	-45.1	-54.0	2.3
3	Мал амьтны болон ургамлын гаралтай тос, өөх	14.8	13.6	-1.3	-8.5	0.8
4	Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	123.7	167.3	43.6	35.2	9.9
5	Эрдэс бүтээгдэхүүн	276.8	386.5	109.7	39.6	22.9
6	Химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн	97.4	124.7	27.3	28.1	7.4
7	Хуванцар болон түүгээр хийсэн зүйлс; хаймар болон түүгээр хийсэн зүйлс	57.8	68.8	11.0	19.1	4.1
8	Арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл	1.5	1.6	0.2	13.0	0.1
9	Мод, модон эдлэл	8.8	21.1	12.3	140.3	1.3
10	Цаас болон картон, тэдгээрээр хийсэн зүйлс	14.7	20.8	6.0	41.0	1.2
11	Нэхмэлийн материал болон нэхмэл эдлэл	22.3	33.4	11.1	49.6	2.0
12	Гутал, малгай, төрөл бүрийн бусад зүйл	4.7	6.7	2.0	41.8	0.4
13	Чулуу, гөлтгөнө, шөрмөсөн чулуу, гялтгануур болон тэдгээртэй төстэй материалаар хийсэн бүтээгдэхүүн	31.7	42.5	10.9	34.3	2.5
14	Сувд, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос	1.9	2.7	0.8	44.8	0.2
15	Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн	99.8	159.2	59.4	59.5	9.4
16	Машин, механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг	263.0	269.1	6.1	2.3	15.9
17	Авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд, анги	346.7	222.0	-124.7	-36.0	13.1
18	Хараа зүй, гэрэл зураг, хэмжүүр, хяналт, эмнэлгийн багаж хэрэгсэл, цаг, хөгжмийн зэмсэг эдгээрийн эд анги	28.6	39.0	10.4	0.0	0.0
19	Аж үйлдвэрийн төрөл бүрийн бараа	1.5	0.4	-1.1	0.0	0.0
20	Урлагийн бүтээл, цуглуулга хийх, зориулалтын зүйлс ба эртний үнэт дурсгалын зүйлс	19.0	31.9	12.9	0.1	0.0
21	Бусад	0.0	0.0	0.0	0.0	0.0
	ДҮН	1,523.7	1,690.7	167.0	11.0	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Дөрөв. Улсын төсвийн гаалийн орлого бүрдэлт

Гаалийн байгууллага нь 2024 оны эхний 11 сард нийт 6,256.0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс **6,113.1** тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн бөгөөд гүйцэтгэл **97.7** хувьтай байна.

Орлогын гүйцэтгэлийг өнгөрсөн онтой харьцуулбал нийт орлого өнгөрсөн оны мөн үеэс 1,297.6 тэрбум төгрөгөөр буюу 26.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 8. Татварын орлогын гүйцэтгэл

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2023.11	2024.11		Өмнөх оны мөн үетэй харьцуулахад		Төлөвлөгөөтэй харьцуулахад	
	Гүйц.	Төл.	Гүйц.	Зөрүү	Хувь	Зөрүү	Хувь
Нийт орлого	4,815.5	6,256.0	6,113.1	1,297.6	26.9	-142.9	-2.3
Гаалийн албан татвар	1,324.6	1,812.5	1,629.9	305.3	23.0	-182.6	-10.1
Нэмэгдсэн өртгийн албан татвар	2,850.2	3,760.2	3,564.3	714.1	25.1	-195.9	-5.2
Архи, дарсны онцгой албан татвар	34.9	47.2	53.6	18.7	53.6	6.4	13.6
Тамхины онцгой албан татвар	134.0	141.7	135.5	1.5	1.1	-6.2	-4.4
Шар айрагны онцгой албан татвар	8.1	9.4	12.0	3.9	48.1	2.6	27.7
Суудлын автомашины онцгой албан татвар	291.2	311.6	546.4	255.2	87.6	234.8	75.4
Автобензин, дизель түлшний онцгой албан татвар	12.5	10.0	3.1	-9.4	-75.2	-6.9	-69.0
Автобензин, дизель түлшний албан татвар	19.4	26.4	23.4	4.0	20.6	-3.0	-11.4
Экспортын татвар	0.05	0.04	0.02	0.0	-51.1	0.0	-42.1
Татварын дүн	4,674.9	6,119.0	5,968.2	1,293.3	27.7	-150.8	-2.5
Хураамж	112.6	122.8	132.5	19.9	17.7	9.7	7.9
Өөрийн орлого	28.0	14.2	12.4	-15.6	-55.7	-1.8	-12.7

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Орлогын гүйцэтгэлийг өнгөрсөн онтой харьцуулбал нийт орлого өнгөрсөн оны мөн үеэс 1,297.6 тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүнд:

- Нэмэгдсэн өртгийн албан татвар 714.1 тэрбум төгрөг;
- Гаалийн албан татвар 305.3 тэрбум төгрөг;
- Суудлын автомашины онцгой албан татвар 255.2 тэрбум төгрөг;
- Хураамжийн орлого 19.9 тэрбум төгрөг;
- Архи, дарсны онцгой албан татвар 18.7 тэрбум төгрөг;
- Автобензин, дизель түлшний албан татвар 4.0 тэрбум төгрөг;
- Шар айрагны онцгой албан татвар 3.9 тэрбум төгрөг;
- Тамхины онцгой албан татвар 1.5 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна

Харин автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар 9.4 тэрбум төгрөг, өөрийн орлого 15.6 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Тав. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт

2024 оны эхний 11 сард нийт импортод татвартай импорт **93.8** хувь, татвараас чөлөөлөгдсөн импорт үнийн дүнгээрээ **6.2** хувийг тус тус эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад татвартай импорт **6,682.1** тэрбум төгрөгөөр буюу 24.8 хувиар өссөн бол, татвараас чөлөөлөгдсөн импорт **453.8** тэрбум төгрөгөөр буюу 25.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 9. Импортын бүтэц

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	эхний 11 сар		Өмнөх оны мөн үетэй харьцуулахад		Импортод эзлэх хувь
	2023	2024	Зөрүү	Хувь	
Татвартай импорт	26,914.4	33,596.6	6,682.1	24.8	93.8
Татвараас чөлөөлөгдсөн импорт	1,771.4	2,225.3	453.8	25.6	6.2
Нийт	28,685.8	35,821.8	7,136.0	24.9	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Импортын **2,225.3** тэрбум төгрөгийн бараанд 2024 оны эхний 11 сард ногдуулвал **325.8** тэрбум төгрөгийн татварыг холбогдох хууль тогтоомжийн дагуу татвараас чөлөөлөгдсөн байна.

Хүснэгт 7. Импортын гүйцэтгэл, барааны бүлгээр

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Үнийн дүн мян.төг	Дүн
Гадаадын хөрөнгө оруулалт: УБТЗ	511.2	79.3
Засгийн газрын болон Олон улсын байгууллагын тусламж	262.1	40.9
Засгийн газрын болон олон улсын байгууллагын зээл	411.3	63.2
Иргэний агаарын зорчигч тээврийн хөлөг онгоц, түүний сэлбэг	203.4	32.3
Сэргээгдэх эрчим хүчний судалгаа шинжилгээний болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, сэлбэг	146.4	21.1
ХАА-н зориулалттай тоног төхөөрөмж, ургамал хамгааллын бодис	212.5	22.3
Хийн түлш тэдгээрийн тоног төхөөрөмж	93.0	14.4
Бусад	385.4	52.4
Нийт дүн	2,225.3	325.8

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Зургаа. Улсын төсвийн гаалийн орлогод нөлөөлсөн хүчин зүйлс

Гаалийн байгууллага нь УИХ, Засгийн газраас баталсан хууль тогтоомжийг хэрэгжүүлж, татварын хойшлуулалт, чөлөөлөлт, хөнгөлөлтөөр 224.4 тэрбум төгрөгийн татварыг улсын төсөвт төвлөрүүлэх боломжийг алдсан байна. Үүнд:

Тариф хувь хэмжээний бууралт **5.9** + Татварын чөлөөлөлт **5.5** + ханшний нөлөөллөөр **151.3** + Татварын хойшлуулалт **61.7 = 224.4** тэрбум төгрөг

Ханшны нөлөөлөлөөр нийт 121.0 тэрбум төгрөг

Ханшийн 2.3 хувийн бууралтаас гаалийн байгууллага нь нийт 121.0 тэрбум төгрөгийг Улсын төсөвт төвлөрүүлэх боломж алдагдсан.

Хүснэгт 11. Ханшийн нөлөөлөл

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	эхний 11 сар		өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад	
	2023	2024	Өөрчлөлт	Дүн
Татвартай импорт /сая ам. доллар/	7,784.2	9,967.1	2,182.9	28.0
Татвартай импорт/тэрбум төгрөг/	26,914.4	33,596.6	6,682.1	24.8
Гаалийн албан татвар болон Нэмэгдсэн өртгийн албан татвар /тэрбум төгрөг/	4,174.8	5,194.2	1,019.4	24.4
Дундаж ханш /төгрөг/	3,457.6	3,370.8	-86.8	-2.5
2023 оны эхний 11 сарын дундаж ханшаар тооцсон импорт / тэрбум төгрөг/	26,914.4	34,461.8	7,547.4	28.0
2023 оны эхний 11 сарын дундаж ханшаар тооцсон татвар /тэрбум төг/	4,174.8	5,345.5	1,170.7	28.0
Ханшны зөрүүнээс буурсан татвар /тэрбум төг/		151.3		

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Тарифын хөнгөлөлт, татварын чөлөөлөлт

а) Загийн газрын 2024 оны 188-р тогтоолоор батлагдсан Цементийн албан татварын хувь хэмжээг 20 хувь байсныг 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 2024 оны 10 дугаар сарын 01-ныг хүртэл хугацаанд 5% болгон бууруулсан тогтоолыг тарифын санд оруулж хэрэгжилтэд хяналт тавьсан. Нийт 10.8 сая ам.долларын дүн бүхий 174.4 мянган тонн, **5.5** тэрбум төгрөгийн татварыг хөнгөлсөн байна.

б) 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Засгийн газрын 180 дугаар тогтоолыг тус тус үндэслэн импортын малын тэжээл болон гурил бүхий бараанд ногдуулвал зохих **5.9** тэрбум төгрөгийн гаалийн албан татварыг чөлөөлжээ.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС